

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 25 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11.00 цагт эхэлж, 15.00 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 4 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	ЗГ-ын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газрын хэлтсийн (4) даргын албан тушаалуудад томилогдох удирдах ажилтан нарт дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд Халтарын Болдмандалыг, Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд Батсүрэнгийн Амгаланбатыг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын албан тушаалд Аюушийн Мөнхбатыг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансарт санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн Ажлын албаны ерөнхий менежерийн албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн Ерөнхий менежерийн албан тушаалд Цолмонгийн Итгэлийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн захирагч О.Нигаметэд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн даргын албан тушаалд Очирын Лхагварэнцэнг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж МУ-ын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Н.Энхболдод санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
4	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга асан О.Байгалмаагийн гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх асуудал нь төрийн байгууллагын шуурхай удирдлагад хамаарах бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх мэдлийн асуудал тул Төрийн албаны зөвлөлөөс түүний өгсөн оноог нэмэх, эсхүл хасах боломжгүй бөгөөд хоёр тал тохирох ёстой байв. Төсвийн ерөнхийлөн захирагч Т.Гандигийн гарын үсэг бүхий, О.Байгалмаа уг үнэлгээг хүлээн зөвшөөрөөгүй үр дүнгийн гэрээ (2009 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн үр дүнгийн гэрээний биелэлт)-ний “Илтгэх хуудас”-нд 64.6 оноо өгснийг ерөнхий

		дүнгээр нь авч үзвэл бодитой үнэлгээ болжээ гэж дүгнэснийг Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт болгон хүргүүлэхээр тогтов.
5	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тухай	Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын даргын ажлын байрны тодорхойлолтыг зохих журмын дагуу хүлээн авч уг албан тушаалын сул орон тоог Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45-д зааснаар нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтыг нээлттэй өрсөлдөөний зарчмаар явуулахаар тогтож, ажлын байрны тодорхойлолтыг нь Хөвсгөл аймгийн Засаг даргаас холбогдох журамд заасны дагуу стандартаар гаргуулан авч нийтийн хэвлэл мэдээллээр зарлах нь зүйтэй гэж үзэв.
6	Баян-Өлгий аймгийн 5 дугаар багийн иргэн А.Атай, Дэлүүн сумын 9 дүгээр багийн иргэн И.Сапаргүл нарын ирүүлсэн гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Зөвлөл шалгасан байдлыг нь зүйтэй гэж үзээд, бодит байдал дээр ийм ийм байсан гээд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад уламжилж, санал болгосон зүйлийг дахин авч үзээд хариу ирүүлэх нь зүйтэй гэж үзэв.
7	Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын газрын Сургалтын албаны дарга Б.Жамбалдоржийн гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	<p>1.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 10 жилийн 4 дүгээр сургуулийн захирал (ерөнхий менежер)-ын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт нь ТАЗ-өөс 2004 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр гаргасан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах зөвлөмж”-ийг зөрчсөн байх тул Баянхонгор аймаг дахь ТАЗСЗ-ийн 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 10 жилийн 4 дүгээр сургуулийн захирлын албан тушаалд Ц.Загдсүмийг нэр дэвшүүлсэн 114 дүгээр тогтоолыг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх,</p> <p>2.”Дүгнэлт хүргүүлэх тухай” Баянхонгор аймаг дахь ТАЗСЗ-ийн 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 114 дүгээр тогтоол, “Ажилд томилох тухай” Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 150 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгох,</p> <p>3.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 10 жилийн 4 дүгээр сургуулийн захирлын ажлын байранд дахин ТАЗ-ийн 2003 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга (захирал, эрхлэгч)-ыг сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалт явуулахыг Баянхонгор аймаг дахь ТАЗСЗ-ийн дарга Ч.Гомбодоржид үүрэг болгох,</p> <p>4.ТАТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу энэхүү тогтоолыг биелүүлэх арга хэмжээ авахыг Баянхонгор аймаг дахь ТАЗСЗ-ийн дарга</p>

		Ч.Гомбодорж, мөн аймгийн Баянхонгор сумын Засаг дарга А.Амартүвшин нарт даалгах тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
8	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тухай	<p>1.ЗТБХБЯ-ны дэргэдэх ТАЗСЗ-ийн саналын дагуу ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг татан буулгах,</p> <p>2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан тус салбар зөвлөлийн эрх, үүргийг ЗТБХБЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хариуцуулах,</p> <p>3.Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх ТАЗСЗ-д олгосон 36 дугаар тэмдгийг хураан авч зохих журмын дагуу шийдвэрлэхийг Ажлын албаны дарга Ц.Самбаллхүндэвт даалгах тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>4.Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 19 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн “гишүүд” гэсэн хэсэгт “Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дарга” гэж нэмэх,</p> <p>5.Энэхүү тогтоолыг ЗТБХБЯ-ны дэргэдэх ТАЗСЗ-д мэдэгдэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	Бусад асуудал: МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэд даргын тухай	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэд даргын албан тушаалд тухайн үеийн Байгаль орчны яамны дэргэдэх ТАЗСЗ-ийн 2005 оны 06/03 дугаар дүгнэлтээр Зинамядарын Батбаярыг томилуулахаар нэр дэвшүүлсэн нь нэгэнт сонгон шалгаруулалт нь тухайн үеийн холбогдох журмын дагуу зохион байгуулагдсан байх тул дээрх дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, Засгийн газрын агентлаг Биеийн тамир, спортын газрын дэд дарга Д.Сүрэнхорлоогийн нэгэн адил шийдэж болох боловч хуулиа барьж Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18 ³ -ын 3-т заасны дагуу ТАЗ-ийн дүгнэлт гаргаж ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны томилгоог хийх нь зүйтэй гэж үзэн дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.